



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022-03-28

Дугаар: А/171

Эрдэнэт

Нэмэлт амин дэмээр хангахад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, 11.1.8, Засгийн газрын 2017 оны 78 дугаар тогтоолоор батлагдсан "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" үндэсний хөтөлбөрийн 3.2.1.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дүгээр сарын 02-ны өдрийн ээлжит VI хуралдааны 06/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийгмийн халамж нэн шаардлагатай бүлгийн жирэмсэн болон хөхүүл эхчүүдийг нэмэлт амин дэмээр хангахад дэмжлэг үзүүлсүгэй.
2. Зардалд шаардагдах 6,999,852 (Зургаан сая, есөн зуун ерэн есөн мянга, найман зуун тавин хоёр) төгрөгийг төсөл хөтөлбөрийн зардлын (Жирэмсэн болон хөхүүл эхчүүдийг амин дэмжүүлэх, цус цусан бүтээгдэхүүний хангалтыг нэмэгдүүлэх ажлуудыг зохион байгуулах) зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс (Н.Бямбацэцэг)-т зөвшөөрсүгэй.
3. Батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулан, үр дүнг тайлагнаж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Д.Сүхээ) -т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.БАТЖАРГАЛ